



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 22 өдөр

Дугаар А/37

Мандалговь

Газар эзэмших эрхийг  
шилжүүлэх тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйл 38.1,2,4 дэх заалт, газар эзэмших эрхийг шилжүүлэн авах байгууллагын хүсэлтийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэр (Өлзий-Дундговь ХХК-ний урд талд) байршилтай Дундговь аймгийн нэгдсэн эмнэлэг (РД:9035354)-ийн төрийн үйлчилгээний зориулалттай 1700 м.кв (0,17га) газраас 270 м.кв (0,02 га) газрыг Дундговь аймгийн эрүүл мэндийн газар (РД:9034064)-т зориулалтаар нь 13 жилийн хугацаатай эзэмшүүлэхээр эрхийг шилжүүлж, үлдсэн газрын хэмжээг одоо байгаа 397м.кв (0,03га)-аар тогтоон Дундговь аймгийн нэгдсэн эмнэлэг (РД:9035354)-т зориулалтаар нь 13 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх байгууллагуудтай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгохыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2006 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 22 дугаар захирамжийн холбогдох хэсэг мөн газар эзэмших 0009977 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010055